

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН ТЭНГЭР ДААТГАЛ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

ДУГНЭЛТ

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгаар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгаар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ийн дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

ДУГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм" -ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд үг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохиистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээв.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторовн тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохиистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байгаа илрүүлэн гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайлангуудад үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэх санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохиистой аудитын нотолгоо олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхиуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохиистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохиистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторовн тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторовн тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулсан шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн харах хэрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Компанийн 2020 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн тайланг өөр аудитор шалгасан бөгөөд 2021 оны 6 сарын 28-ны өдөр санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Энэхүү тайланг өөр ямар нэг зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан

Батбаярын Мөнхжин
Захирал

Баталсан

Адриан Чу
Партнер

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31 МЯН.ТӨГ	2020/12/31 МЯН.ТӨГ
ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	372,658	1,122,084
ХУГАЦААТ ХАДГАЛАМЖ	23,095,352	19,421,764
ДАНСНЫ БА БУСАД АВЛАГА	1,339,795	1,841,134
ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ХОЙШЛОГДСОН ЗАРДАЛ	610,842	485,002
ДАВХАР ДААТГАГЧИЙН ОРЛОГОД ТООЦООГҮЙ НӨӨЦ	1,794,691	1,977,341
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ	219,400	164,883
БАРАА МАТЕРИАЛ	23,021	62,107
ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ	65,597	51,607
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,119,463	1,366,897
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	85,107	149,272
НИЙТ ХӨРӨНГӨ	28,725,926	26,642,091

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

ӨР ТӨЛБӨР	2021/12/31 МЯН.ТӨГ	2020/12/31 МЯН.ТӨГ
ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НӨӨЦ САНГУУД		
ДАНСНЫ БА БУСАД ӨГЛӨГ	11,607,375	11,831,894
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ӨГЛӨГ	2,545,306	2,632,266
	11,171	109,331
НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,163,852	14,573,491

ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

ХУВЬЦААТ КАПИТАЛ	2021/12/31 МЯН.ТӨГ	2020/12/31 МЯН.ТӨГ
НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ	5,000,000	5,000,000
ЗОХИЦУУЛАГЧИЙН НӨӨЦ	130,000	130,000
ХУРИМТЛАГДСАН АШИГ	1,388,027	1,388,027
	8,044,047	5,550,573
НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	14,562,074	12,068,600

НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	28,725,926	26,642,091
--	-------------------	-------------------

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31 МЯН.ТӨГ	2020/12/31 МЯН.ТӨГ
ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ		
ДААТГАЛЫН НИЙТ ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ	12,133,130	17,577,109
ДАВХАР ДААТГАГЧИД НОГДОХ ХУРААМЖ	-4,534,375	-8,124,419
ОРЛОГОД ТООЦСОН ЦЭВЭР ХУРААМЖ	7,598,755	9,452,690
НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ		
НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ	-2,419,902	-5,253,054
ДАВХАР ДААТГАГЧИД НОГДОХ НӨХӨН ТӨЛБӨР	24,644	428,078
НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЦЭВЭР ЗАРДАЛ	-2,395,256	-4,824,976
ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО	5,203,499	4,627,714
САНХҮҮГИЙН БА БУСАД ОРЛОГО	2,591,177	2,935,689
БУСАД (ГАРЗ) БА ОЛЗ	-58,815	-50,090
БОРЛУУЛАЛТ, ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	-4,985,952	-5,609,854
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	2,749,909	1,903,459
ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	-256,435	-219,364
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ	2,493,474	1,684,095
БУСАД ИЖ БҮРЭН ОРЛОГО	-	-
НИЙТ ИЖ БҮРЭН ОРЛОГО	2,493,474	1,684,095